



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 1147

Улаанбаатар хот

Албан хаагчдын 2023 оны ажлын  
гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг  
үнэлэх үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6.1 дэх заалт, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Газрын албан хаагчдын 2023 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний багийн ахлагч:	Д.Ганболд	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүн:	В.Батчимэг	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
	О.Нямбат	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
	Б.Энхцэцэг	Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Ш.Ундармаа	Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

2. Албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг хянаж баталгаажуулан тайланг 2023 оны 12 дугаар сарын 10-ны дотор байгууллагын үнэлгээний багт хүлээлгэн өгөхийг нэгжийн дарга нарт даалгасугай.

3. Байгууллагын үнэлгээний баг нэгжийн дарга нарын баталгаажуулсан албан хаагчдын гүйцэтгэлийн тайланг хянаж 2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор дүгнэж, хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг боловсруулан танилцуулахыг үнэлгээний баг /Д.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

1150500286